



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/349

Улаанбаатар хот

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.14, 5.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 2.1.12.2, 2.1.12.5, 2.1.14.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг салбар дундын уялдаатайгаар зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлэн хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ дотоод аудитын газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.

САЙД



С.ЭНХБОЛД

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 05 дугаар сарын 31
өдрийн 1/349 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Зорилго		Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулах				
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүн амын суурьшлын орчны агаар, ундны усны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт сайжирч, хөрсний бохирдолтын түвшин буурч, орчны бохирдлоос үүдэлтэй хүн амын өвчлөл, нас баралт буурна.				
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа	
Зорилт 1. Агаарын чанарыг сайжруулж, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах						
Үйл ажиллагааны чиглэл 1. Агаарын чанарыг сайжруулах орчныг бүрдүүлэх						
1.1.1	Агаарын тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	Нэмэлт өөрчлөлт орсон хууль	Агаарын тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, УИХ-аар батлуулсан байна.	ОББҮХ	СЯ	2021
1.1.2	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын агаарын чанарын дэд бүтцийг сайжруулах	Хамрагдсан сумын ӨЭМТ-ийн тоо	Өрхийн эрүүл мэндийн төвд Агаар сэлгэлтийн механик систем, Агаарын чанарыг хянах бага оврын төхөөрөмжийг суурилуулсан байна.	ЭМЯ, НҮБХС, ШХА	АНЗДТГ	2021-2022
1.1.3	Дотоод орчны агаарын стандарт боловсруулж, батлуулах	Батлагдсан стандарт	Дотоод орны агаарт тавих үнэлгээ, хяналт сайжирна.	НЭМҮТ	Ажлын хэсэг, ДЭМБ	2021
1.1.4	Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц (СНІР)-ыг нийслэл хот, аймгийн төв, хот суурин газруудад түгээн дэлгэрүүлэх, өрх, хүүхдийн зуны кэмп, аялал жуулчлалын гэр кэмп, гэр цэцэрлэгт нэвтрүүлэх, ногоон зээл, бусад санхүүгийн бүтээгдэхүүнийг түгээх	Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багцыг (СНІР) хэрэглэж ногоон зээлд хамрагдсан аймаг, сум, дүүрэг, цэцэрлэг, өрхийн тоо	Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багцыг (СНІР) хэрэглэсэн аймаг, сум, дүүрэг, цэцэрлэг, өрхийн тоо өссөн байна.	ОББҮХ, АНЗДТГ	ЭМЯ, ШУТИС, НҮБХС, ОУТББ, ТоС холбоо	2021-2024
Үйл ажиллагааны чиглэл 2. Агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тандан судлах						
1.2.1	Улирлын чанартай амьсгалын замын цочмог халдварт өвчин дэгдэх үед эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах	ЭМС-ын тушаал	Бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах нөхцлийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад бүрдүүлсэн байна.	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллагууд	2021-2024
1.2.2	Агаарын бохирдол ихтэй бүс нутаг агаарын бохирдлоос үүдэлтэй өвчин эмгэг, тухайлбал, ургийн гажиг, хүүхдийн оюун ухааны хөгжил зэрэгт нарийвчилсан судалгаа хийх, судалгааны дүнг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг хангах	Судалгааны ажлын тайлан, зөвлөмж Судалгааны дүнд үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Судалгаа хийгдэж, үр дүнг олон нийтэд мэдээлсэн байна. Төлөвлөгөө боловсруулж хэрэгжсэн байна.	НЭМҮТ, АШУУИС-ийн НЭМС, ЭХЭМҮТ, МАУА	ЭМЯ, НҮБХС, ДЭМБ	2022-2024
1.2.3	Ажлын онцлогоос хамаарч гадаа байнга ажилладаг замын цагдаа, хот тохижилтын үйлчилгээний ажилтан,	Үнэлгээний тайлан	Улаанбаатар хотын Замын цагдаагийн албаны зохицуулагч цагдаа, Хот тохижилтын үйлчилгээний ажилчид,	АШУУИС-ийн НЭМС	НЗДТГ, ЗЦА	2023

1.2.4	Шатахуун түгээх станцын түгээгч зэрэг ажилтны дунд агаарын бохирдлын өртөлтийн үнэлгээ хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Хяналт, үнэлгээний тайлан	Шатахуун түгээх станцын түгээгч нарт агаарын бохирдлын өртөлтийн үнэлгээ хийгдсэн байна.	МХЕГ, НМХГ	НЗДТГ, НҮБХС	2022-2024
1.2.5	Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил мэдээлэх	Мэдээллийн нэгдсэн систем	Дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил мэдээлсэн байна.	МХЕГ, НМХГ	ЭМЯ, БХБЯ, НҮБХС	2021-2024
1.2.6	Эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх явцад дотоод орчны барилгын материалын аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийж, мэдээллийн нэгдсэн системтэй болох	Үнэлгээний тайлан	Дотоод орчны барилгын материалд хяналт шинжилгээ хийж дүнг олон нийтэд мэдээлсэн байна.	НЭМҮТ	НҮБХС	2022-2023
1.2.7	Ногоон технологи, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхэд бий болох нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн үр өгөөжийг үнэлж, нийтэд танилцуулах	Батлагдсан хамтарсан сайдын тушаал	Батлагдсан тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны дагуу салбар дундын судалгааны ажил хийгдсэн байна	БОАЖЯ, ОББҮХ, НҮБХС	ЭМЯ, БШУЯ, ШУА, салбарын бусад яамд	2021-2024
1.2.8	Агаарын бохирдлын чиглэлээр хэрэгжүүлэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг салбар бүрээр тодорхойлж, хэрэгжилтийг хангах	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын тайлан, шинжлэх ухааны өгүүлэл, бодлогын зөвлөмж	Судалгаа хийгдэж, үр дүнг олон нийтэд мэдээлсэн, тоо, баримт, нотолгоонд суурилсан бодлого гарсан байна.	БОАЖЯ, ОББҮХ	ЭМЯ, БШУЯ, ШУА, салбарын яамд, НҮБХС	2021-2024
1.2.9	Хот, суурин газрын төлөвлөлт, хөгжил, агаар бохирдуулагч эх үүсвэр (эрчим хүч, тээвэр гэх мэт эдийн засгийн салбар), агаарын бохирдол ба ядуурал, нийгмийн асуудал, эдийн засгийн хохиорол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг тэргүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээний ажил хийх, тоо, баримтыг бүрдүүлж, дүн шинжилгээ хийх	Байгальд ээлтэй дулааны технологи	Байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэн туршиж, эрчим хүчний хэмнэлт, үр дүнг тооцсон байна.	НЭМГ	ЧД, БЗД, ХУД-ийн ӨЗМТ, ЭМСХХ-6 төсөл	2021-2023
Үйл ажиллагааны чиглэл 3. Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх						
1.3.1	Агаарын бохирдол ихтэй бүс нутгийн нэг хүртэлх насны хүүхдийг пневмококкийн эсрэг дархлаажуулалтад хамруулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Агаарын бохирдол ихтэй бүс нутгийн нэг хүртэлх насны хүүхдийг пневмококкийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан байна.	ХӨСҮТ, АНЭМГ	ЭМЯ	2021-2024
1.3.2	Агаарын бохирдол ихтэй бүс нутгийн эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Агаарын бохирдол ихтэй бүс нутгийн эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан байна.	ХӨСҮТ, АНЭМГ	ЭМЯ	2021-2024
1.3.3	Дотоод орчны агаарт хорт бодис болон дэгдэмхий органик бохирдуулагчдыг тодорхойлох	Судалгааны тайлан Зөвлөмж	Дотоод орчны агаарт хорт бодис болон дэгдэмхий органик бохирдуулагчдын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тодорхойлсон байна.	АШУУИС-ийн НЭМС	ЭМЯ, ОББҮХ, ДЭМБ	2021-2024
Үйл ажиллагааны чиглэл 4. Агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар хүн амын дунд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх, олон нийтийн санаачилгыг дэмжих						

1.4.1	Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хийх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, агаарын бохирдлыг бууруулахад иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын санал, санаачлагыг дэмжих	Мэдээлэл сурталчилгааны төлөвлөгөө Боловсруулсан сурталчилгааны материал	сургалт, аяны сургалт	Хүн амд зориулсан санамж, гарын авлага, лайв, видео болон онлайн хичээл боловсруулж нийтийн хүртээл болгосон байна.	ЭМЯ, АНЗДТГ ЭМЯ, АНЗДТГ, ДЭМБ	БОАЖЯ, НЭМҮТ, АНЭМГ БОАЖЯ, НЭМҮТ, АНЭМГ, БШУЯ НЭМҮТ, АНЭМГ, Монголын скаутын холбоо, ЦУНБХТ	2021- 2024 2021- 2024 2021- 2024
1.4.2	Дам тамхидалтын хор уршгийн талаар иргэдэд зориулсан зөвлөмж, сургалт, сурталчилгааны материал боловсруулан түгээх	Дам тамхидалтын хор уршгийн талаар иргэдэд зориулсан сургалт зөвлөмж, сурталчилгааны материал	сургалт	Дам тамхидалтын талаарх олон нийтийн зориулсан мэдээлэл сургалт сурталчилгааны материалын тоо, төрөл, мэдээлэл авсан хүний тоо жил бүр нэмэгдсэн байна.	ЭМЯ, ДЭМБ	Харьяа байгууллагууд	2021- 2024
1.4.3	Нялх, бага насны хүүхдийг эхийн сүүгээр дагнаж хооллох, 2 нас хүртэл үргэлжлүүлэн хооллохыг сурталчилсан материалын тоо, төрөл, мэдээлэл авсан хүний тоо жил бүр нэмэгдсэн байна.	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны стратеги Сурталчилгааны материал	сургалт	Нялх, бага насны хүүхдийг эхийн сүүгээр дагнаж хооллох, 2 нас хүртэл үргэлжлүүлэн хооллохыг сурталчилсан материалын тоо, төрөл, мэдээлэл авсан хүний тоо жил бүр нэмэгдсэн байна.	ЭМЯ	Харьяа байгууллагууд	2021-2024
Зорилт 2. Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангаж, хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах							
Үйл ажиллагааны чиглэл 1. Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх							
2.1.1	Ус хангагч байгууллагад ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх	Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх багийн сургалт	Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх багийн сургалт	21 аймгийн ус хангагч байгууллагын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх багийг давтан сургах, чадавхжуулсан байна. Ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх багийн сургалт зохион байгуулагдсан байна.	МХЕГ, НЭМҮТ, НМХГ, АШУУИС-ийн НЭМС, УСУГ, ХСУХАТАУ33	ЭМЯ, БХБЯ, ДЭМБ	2021-2024
2.1.2	Жижиг суурин газарт усны аюулгүй байдлын төлөвлөгөөг тухайн орон нутгийн онцлог, хүн амын тоо, ус хангамжийг харгалзан зааврын дагуу боловсруулж хэрэгжүүлэх	ЭМБ, сум, дүүргийн ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө	Хөндлөнгийн аудит	УБ болон 7 аймгийн ус хангагч байгууллагад хэрэгжиж буй усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийгдсэн байна.	МХЕГ, НЭМҮТ, НМХГ, АШУУИС-ийн НЭМС, УСУГ, ХСУХАТАУ33	ЭМЯ, БХБЯ, ДЭМБ	2021-2024
2.1.3	Эрүүл мэнд, байгаль орчны асуудал эрхэлсэн сайд нарын хамтарсан тушаалаар байгуулсан "Ус, ариун цэврийн байгууламжийн ажлын хэсэг"-ийн уулзалтыг хагас жилд зохион байгуулах, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах	Ажлын хэсгийн уулзалтын хөтөлбөр, шийдвэр	Ажлын хэсгийн уулзалтын хөтөлбөр, шийдвэр	Жилд 2 удаа хуралдаж салбар дундын хамтын ажиллагаа сайжирна.	ЭМЯ, БОАЖЯ, УГ	Ажлын хэсэг, ДЭМБ, НУБХС	2021-2024
Үйл ажиллагааны чиглэл 2. Хүн амын ундны ус, ахуйн бохир ус, хөрсний бохирдолтонд эрсдэлийн үнэлгээ хийх							
2.2.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад ундны ус, ариун	Үнэлгээний тайлан	Үнэлгээ хийгдэж, цаашид авах арга хэмжээний саналыг тодорхойлж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	МХЕГ, АНЭМГ, АШУУИС-ийн НЭМС, ТББ	ЭМЯ, ДЭМБ	ЭМЯ, ДЭМБ	2021-2024

2.2.2	цэвэр, эрүүл ахуй, хог хаягдлын менежментэд эрсдэлийн үнэлгээ хийх Үндэсний түвшинд ДЭМБ-ын аргачлалын дагуу хүн амын ундны ус, ариун цэврийн байгууламжийн үнэлгээг 2 жил тутамд хийх	Үнэлгээний тайлан	Үнэлгээний тайланг ДЭМБ-д хүргүүлсэн байна.	ЭМЯ, БОАЖЯ, БХБЯ, БШУЯ	УГ, НЭМҮТ, МХЕГ, ХСУХАТАУЗЗ, ДЭМБ	2021, 2023
2.2.3	"Нийгмийн үзүүлэлтийн түвэр судалгаа"-ны арга, аргачлалд эрүүл ахуйн шаардлага хангасан ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг тооцох аргачлал, асуумжийг шинээр нэмж оруулах, тооцох	Батлагдсан судалгааны арга, аргачлал Судалгааны тайлан	Нийгмийн үзүүлэлтийн түвэр судалгаагаар эрүүл ахуйн шаардлага хангасан ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь тодорхойлогдсон байна.	УСХ	БХБЯ, ЭМЯ, НҮБХС	2023
2.2.4	Хот, суурин газрын хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд эрсдэлт суурилсан хяналт, үнэлгээ хийх	Эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээний тайлан	Эрсдэлд суурилсан хяналт хийж, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ, НМХГ	Бүх шатны Засаг дарга	2022-2024
2.2.5	Хөдөөгийн хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээг хийх	Хяналт, үнэлгээний тайлан	Эрсдэлд суурилсан үнэлгээний зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ, НЭМҮТ	ЭМЯ	2022-2024
2.2.6	Ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээ хийх	Хамгаалагдсан ундны усны эх үүсвэрт хяналт, үнэлгээ	Хамгаалалтын бүсийн дэглэмд хяналт, үнэлгээний зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, мөрдүүлнэ.	БХБЯ, БОАЖЯ	МХЕГ, Бүх шатны Засаг дарга	2022-2024
2.2.7	Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинд хяналт, үнэлгээ хийх	Хяналт, үнэлгээ	Эрсдэлд суурилсан хяналт, үнэлгээ, судалгааны зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ, НМХГ	АНЗДТГ	2022-2024
2.2.8	Хот, суурин газрын суурьшлын бүс орчмын хөрсний бохирдлын байдалд үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох	Хяналт, үнэлгээний тайлан	Зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МХЕГ, НМХГ	Бүх шатны Засаг дарга	2022-2024
2.2.9	Ундны ус хангамжийн зориулалттай гүний худуудын усны чанарын мониторингийн судалгааг тогтмол хийж, онлайн мэдээллийн систем байгуулж, ундны усны чанарыг сайжруулах зорилгоор тохирох шүүлтүүр суурилуулах арга хэмжээ авах	Усны чанарын шинжилгээний мэдээллийн сан	Ундны усны чанарын шинжилгээний мэдээллийн сан бүрдэж, чанарыг нь сайжруулах арга хэмжээг тогтмол авдаг болсон байна.	ХСУХАТАУЗЗ	БХБЯ, ШУА, МХЕГ, НҮБХС	2021-2024
2.2.10	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээний чанарт мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах	Зөвлөмж	Аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны цэвэрлэгээний чанар сайжирсан байна.	ЗӨСҮТ, НЗАА	Аж ахуйн нэгж, байгууллага	2021-2024
Үйл ажиллагааны чиглэл 3. Хүн амд ундны усны чанар болон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдээлэл, сурталчилгаа хийх, олон нийтийн санаачилгыг дэмжих						
2.3.1	Хүн амд ундны усны чанар, аюулгүй байдал болон сайжруулсан ариун цэврийн байгууламжийн талаар мэдлэг, ойлголт бий болгох, эрүүл амьдрах хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа өргөжүүлэх, энэ асуудлаар иргэд олон нийт, төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжих	Мэдээлэл сурталчилгааны төлөвлөгөө Боловсруулсан сургалт сурталчилгааны материал Сургалт, сурталчилгаа, компанит ажил, аян Зориулалтын бус газарт бие засахгүй байх сурталчилгаа	Хүн амд олон нийтийн хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр сурталчилсан байна. Хүн амд зориулсан санамж, гарын авлага, инфографик боловсруулж нийтийн хүртээл болгосон байна. Сургалт, сурталчилгаа, компанит ажил, аяныг тогтмолжуулж, иргэд олон нийт, ТББ-ын санаачлыг дэмжиж ажилласан байна. Иргэдийн оролцоотой ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөдөлгөөн өрнүүлж, зориулалтын бус газарт бие засахыг байгууллага	АНЗДТГ АНЗДТГ, МХЕГ АНЗДТГ, ТББ МУЗН, Орон нутгийн төрийн захиргааны байгууллага	НЭМҮТ, АНЭМГ НЭМҮТ, АНЭМГ, ДЭМБ НЭМҮТ, АНЭМГ, ДЭМБ НЭМҮТ, АНЭМГ, НҮБХС	2021-2024 2021-2024 2021-2024 2021-2024

					сурталчилан, урамшууллын болон гэрчилгээ олгох механизмийг бүрдүүлсэн байна.				
2.3.2	Нүхэн жорлон, угаадасны нүх MNS 5924:2014 стандартыг сурталчилах, мөрдүүлэхэд төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Зөвлөмж, товхимол	Зөвлөмж, товхимол		Ариун цэврийн байгууламжийг сайжруулах, хөрсний бохирдлоос сэргийлэх талаар зөвлөмж, товхимол, гарын авлага, инфографик боловсруулж олон нийтийн хүртээл болгосон байна.	НЭМҮТ, МХЕГ, НМХГ	ДЭМБ, ТББ	2021-2024	
2.3.3	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох	Сайжруулсан хүнэн жорлон, ариун цэврийн байгууламж	Сайжруулсан хүнэн жорлон, ариун цэврийн байгууламж		Сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна.	ЭМЯ, НҮБСХ, Койка	Эрүүл мэндийн байгууллагууд	2021-2022	
Зорилт 3. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа, үнэлгээний чанарыг сайжруулах									
Үйл ажиллагааны чиглэл 1. Орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа, үнэлгээ хийх тогтолцоог боловсронгуй болгох									
3.1.1	Орчны эрүүл мэндийн тандалтын тогтолцооны хүний нөөцийг чадавхжуулах	Товхимол	Товхимол		Орчны эрүүл мэндийн тандалтын мэдээгээр сар, улирал, жилээр товхимол гарсан байна.	НЭМҮТ	МХЕГ, ЭМХТ, ЦУОШГ	2021-2024	
3.1.2	Орчны эрүүл мэндийн тандалт, судалгааны мэдээллийн сан байгуулах, цахим хуудас ажиллуулах	Сургалтын хөтөлбөр Сургалтын авлага Сургалтанд оролцогчдын тоо	Сургалтын хөтөлбөр Сургалтын авлага Сургалтанд оролцогчдын тоо		Жил бүр 20-нас доошгүй орчны эрүүл мэндийн мэргэжилтэн, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний мэргэжилтэн, эрүүл ахуй, халдвар хамгааллын улсын байцаагч, тархаар судлаач мэргэжилтэнг сургалтад хамруулж чадавхжуулсан байна.	НЭМҮТ, ДЭМБ, НҮБХС	ЭМЯ, МХЕГ, ЭМХТ, ЦУОШГ	2021-2024	
3.1.3	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний алба байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний алба байгуулах Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлал шинэчлэх Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний шинжээч бэлтгэх	Мэдээллийн сан цахим программ		Тандалт, судалгааны мэдээллийн сан бүрдэж, цахим программаар мэдээллийг тогтмол авч шийдвэр гаргагч, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	НЭМҮТ	Бусад яам, агентлаг, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	2021-2024	
3.1.4	Орчны эрүүл мэндийн төлөв байдлын эмхэтгэл-3 боловсруулах	Орчны эрүүл мэндийн төлөв байдлын эмхэтгэл-3	Орчны эрүүл мэндийн төлөв байдлын эмхэтгэл-3		Хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судалж, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	ЭМЯ, НЭМҮТ	Ажлын хэсэг, ДЭМБ	2023	
3.1.5	Эрүүл ахуй, тархаар судлаачдын Үндэсний IV зөвлөлгөөн зохион байгуулах	Үндэсний IV зөвлөлгөөн	Үндэсний IV зөвлөлгөөн		Зөвлөлгөөнөөс гарсан уриалга, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	МЭАТСНХ, ЭМЯ, ДЭМБ	НЭМҮТ, МХЕГ, АШУУИС-ийн НЭМС, ХЭСҮТ	2023	
3.1.6	Үндэсний түвшинд биомониторинг хийх эрх зүйн орчныг судлах	Батлагдсан арга аргачлал, стандарт	Батлагдсан арга аргачлал, стандарт		Хүрээлэн байгаа орчны бохирдлоос үүдэлтэй биомониторинг хийх тогтолцоо бүрдсэн байна.	СХЗГ	НЭМҮТ, НҮБХС	2022-2024	
Зорилт 4. Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийн үед хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх									
Үйл ажиллагааны чиглэл 1. Хүн амын дунд уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэг, ойлголт бий болгох, хүн амд эрүүл мэндээ хамгаалах дадал, хандлагыг төлөвшүүлэх									
4.1.1	Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнд дасан зохицох мэдлэг, арга хэрэгсэл, техник, технологийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх	Сургалт сурталчилгаа, гарын авлага, инфографик	Сургалт сурталчилгаа, гарын авлага, инфографик		Гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон байна.	МАУА, НЭМҮТ, ЗЭСҮТ	ЭМЯ, МАУА, АНЭМГ, ДЭМБ	2022-2024	
4.1.2	Фэйсбүүк Чатбот (FB ChatBot), хөгжүүлж, хүүхэд, өсвөр үеийнхний дунд уур амьсгалын өөрчлөлт,	Фэйсбүүк Чатбот (FB ChatBot), судалгааны тайлан, зөвлөмж	Фэйсбүүк Чатбот (FB ChatBot), судалгааны тайлан, зөвлөмж		Судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулж, хүүхдийн байгаль орчны эрхийн асуудлыг салбарын бодлогод тусгасан байна.	БОАЖЯ, БШУЯ	ЭМЯ, НҮБХС, Монголын	2021-2022	

	бохирдол, байгаль орчны бохирдол, доройтол, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаар үндэсний хэмжээний судалгаа авах, үр дүнг хүүхдийн байгаль орчны эрхийн асуудлыг бодлогод тусгахад ашиглах				Скаутын Холбоо, ТББ	
Үйл ажиллагааны чиглэл 2. Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах						
4.2.1	Анагаахын шинжлэх ухааны судлаач, эрдэм шинжилгээний ажилтнуудыг уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны арга зүйн чиглэлээр мэргэшүүлэх	Чадавхи бэхжүүлэх сургалт	Эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг судлаачид, эрдэм шинжилгээний ажилтнуудыг жил бүр чадавхи бэхжүүлэх сургалтад хамруулсан байна.	ШУА, МАУА, НЭМҮГ, ДЭМБ	ХӨСҮТ, ЗӨСҮТ	2021-2022
4.2.2	Хүүхдийн байгаль орчны эрх, эрүүл мэндийн асуудлыг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, салбарын бодлогод тусгах	Батлагдсан бодлогын баримт бичиг	Бодлогын баримт бичигт хүүхдийн байгаль орчны эрх, эрүүл мэндийн асуудлыг тусгасан байна.	БОАЖЯ, ЭМЯ, НҮБХС	БШУЯ	2021-2024
4.2.3	Уур амьсгалын өөрчлөлт ба хүнсний аюулгүй байдал, хүүхдийн хоол тэжээлийн чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил хийх, үр дүнг түгээх	Судалгааны тайлан	Судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох, нотолгоонд суурилсан бодлогын арга хэмжээг төлөвлөхөд ашиглана.	ЭМЯ, НҮБХС	Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага	2022, 2024
Үйл ажиллагааны чиглэл 3. Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх						
4.3.1	Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох ариун цэврийн байгууламжийг сурталчлах хүн амд зориулсан сургалт зохион байгуулах	Сургалт	Зорилтот аймгийн хүн амыг сургалтанд хамруулсан байна.	ЭМЯ, НҮБХС, Койка	АНЭМГ, АНЗДТГ	2021-2024
4.3.2	Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, НЭМ-ийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах	Сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлага, сурталчилгааны материал	5 эрүүл мэндийн байгууллагын боловсон хүчин чадавхижсан байна.	МХЕГ, АШУУИС-ийн НЭМС, ТББ, ДЭМБ	АНЭМГ, АНЗДТГ	2021
4.3.3	Дамжуулагчаар дамжих халдварын эрсдэлийг бууруулах талаар хүн амд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Боловсруулсан сурталчилгааны материал Судалгааны тайлан Сургалтанд оролцогчдын тоо	Дамжуулагчаар дамжих халдварын эрсдэлийг буурсан байна.	ЗӨСҮТ	АНЗДТГ	2021-2024
4.3.4	Шинэ болон дахин сэргэж буй өвчлөлийг тандах, урьдчилан сэргийлэх гарын авлага боловсруулах	Боловсруулсан гарын авлага	Шинэ болон дахин сэргэж буй өвчлөлийг тандах, урьдчилан сэргийлэх гарын авлагыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	ЗӨСҮТ, ХӨСҮТ	Мэргэжлийн салбар зөвлөл	2021-2024
Зорилт 5. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох						
Үйл ажиллагааны чиглэл 1. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй болгон боловсруулах байгууламжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх						
5.1.1	Архангай, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Төв, Говьсүмбэр, Дундговь, Ховд аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийг шинэчилж тоног төхөөрөмжөөр хангах	Төвлөрсөн ариутгалын тасгийн тоо	8 аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгуудын хүчин чадлыг нэмэгдүүлж хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	ЭМЯ, СЯ	АНЭМГ, АЗДТГ, ЭМСХХ-5, ЭМСХХ-6 төсөл	2021, 2023-2024
5.1.2	ХУД-ийн НЭ-ийг байгальд ээлтэй, нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг технологид суурилан шинээр барих	Нүүрс хүчлийн хий бага ялгаруулдаг суурилуулсан барилга	Байгаль орчинд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэн туршиж, эрчим хүчний хэмнэлт, үр дүнг тооцсон байна.	ЭМЯ, НЭМГ	ХУД-ийн НЭ, ЭМСХХ-6 төсөл	2021-2023
Үйл ажиллагааны чиглэл 2. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын анхан шатны бүртгэл, мэдээллийг сайжруулж, нотолгоонд суурилсан үнэн зөв мэдээллийг шийдвэр гаргахад ашиглах						
5.2.1	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын мэдээллийг авах анхан шатны бүртгэл, маяггаар мэдээний сангийн тогтвортой байдлыг хангуулах	Эрүүл мэндийн байгууллагын тоо	Мэдээний сангийн баяжилт хийгдэж хэвшсэн байна.	ХӨСҮТ	АНЭМГ, ЭМБ	2021-2024

Үйл ажиллагааны чиглэл 3. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн чиглэлээр хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх

5.3.1	Эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаар эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал хариуцсан ажилтан болон эрүүл мэндийн ажилтнуудад ажлын байрны сургалтыг тогтмол зохион байгуулах	Сургалтанд оролцогчдын тоо	Ажлын байрны сургалтын төлөвлөгөөнд эмнэлгийн хог хаягдлын менежментийн сургалтыг тусгаж, сургалт зохион байгуулсан байна.	ХӨСҮТ	МХЕГ, АНЭМГ Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн холбоо, ТББ	2021-2024
5.3.2	Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх туршлага судлах сургалтад үе шаттайгаар хамруулах	Сургалтанд оролцогчдын тоо	Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент сайжирсан байна.	ХӨСҮТ	МХЕГ, АНЭМГ	2022-2024
5.3.3	Эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх гарын авлага, сурталчилгааны материал, инфографик хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтэд түгээх	Гарын авлага, мэдээлэл сурталчилгааны материал, инфографик	Эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн хог хаягдлын менежментийн талаарх гарын авлага, сурталчилгааны материалыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.	Харъяа байгууллагууд	ЭМЯ, ДЭМБ	2021-2024

Зорилт 6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах

Үйл ажиллагааны чиглэл 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх

6.1.1	Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, жилийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журамд эрүүл, аюулгүй ажлын байрыг бүрдүүлэхтэй нарийвчлан тусгах	Батлагдсан журам	Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх, жилийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журамд эрүүл, аюулгүй ажлын байрыг бүрдүүлэхтэй холбоотой шалгуур үзүүлэлтийг шинэчилж оруулсан байна.	ЭМЯ	АНЭМГ	2021
6.1.2	Эрүүл мэндийн байгууллагын эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгох санаачилгыг дэмжих, Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх	Шалгарсан байгууллагын тоо	Эрүүл мэндийн дэмжих сангийн дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн байгууллагын эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгох санаачилгыг дэмжин, байгууллагыг шалгаруулж сурталчилсан байна.	ЭМЯ, ХНХЯ	АНЭМГ	2021-2024
6.1.3	Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажилчдыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэгт хамруулахад дэмжлэг үзүүлэх	Үзлэгт хамруулсан хүний тоо	Ажил олгогчид ажилтнуудаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт оруулдаг болох чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн орчин бүрдүүлсэн байна.	ЭМЯ	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг	2021-2024
6.1.4	Эрүүл мэндийн байгууллагын ажлын байрны аюулгүй байдлын талаар баримталж буй стандарт буй стандартад үнэлгээ хийх, шаардлагатай олон улсын стандартыг сонгон нэвтрүүлэх	Үнэлгээний тайлан	Эрүүл мэндийн байгууллагын ажлын байрны аюулгүй байдлын талаар баримталж буй стандартад үнэлгээ хийсэн байна.	ЭМЯ, ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага	2021-2024
6.1.5	Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтныг ажлын байрнаас шалтгаалсан халдвар, гэмтэл авах нөхцөл, ажлын байрны эрсдлийн байдалд нэгдсэн аргачлалаар үнэлгээ хийх	Байгууллага, хүний тоо	Ажлын байрны эрсдэлт нөхцөл байдалд үнэлгээ хийх нэгдсэн аргачлалыг боловсруулж, сургалтад эрүүл мэндийн байгууллагыг хамруулсан байна.	Эрүүл мэндийн байгууллага	ЭМЯ, ЭМХТ, аймаг, нийслэлийн ЭМГ	2021-2024

Зорилт 7. Хүний эрүүл мэндэд химийн бодисын үзүүлэх нөлөөллийг тандан судлах

Үйл ажиллагааны чиглэл 1. Хорт хавдар үүсгэгч бодисын хэрэглээг бууруулах, хориглох

7.1.1	Аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэгт хор судлалын чиглэлээр хор судлалын чиглэлээр ажиллах эмч нарыг мэргэшүүлэн сургах	Сургалтанд оролцогчдын тоо	Нэгдсэн эмнэлэгт хор судлалын чиглэлээр ажиллах мэргэшсэн эмч нарын тоо жил бүр нэмэгдсэн байна.	ЭМХТ	НЭМҮТ	2022-2024
7.1.2	Хор судлалын чиглэлээр үндэсний түвшинд нэгж байгуулах, шинжилгээ хийх лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх	Тоног төхөөрөмж	Хор судлалын чиглэлээр лабораториудын хүчин чадал нэмэгдсэн байна.	НЭМҮТ	МХЕГ, АШУУИС-ийн НЭМС	2021-2024
7.1.3	Химийн бодисын аюулгүй байдал, тандал судалгаа хийх, эрх зүйн орчныг шинэчлэх, нэгдсэн сан бий болгох	Мэдээллийн сангийн журам, дүрэм, заавар	Химийн бодисын аюулгүй байдал, тандал судалгааны мэдээлэл цуглуулах, нэгтгэх, мэдээлэл солилцох, мэдээний сан бий болгох эрх зүйн орчин бүрдсэн байна.	ЭМЯ, НЭМҮТ	МХЕГ, ХАБЭМТ, АНЭМГ	2022-2024
7.1.4	Нийтийг хамарсан химийн бодисын хордлогын үед нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг авах, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Гарын авлага, ном, товхимол	Химийн бодисын хордлогын үед нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг авах, чадавх бэхжинэ.	ЭМЯ	НЭМҮТ, ОБЕГ	2022-2024
7.1.5	Хар тугалгагүй будаг хууль боловсруулах болон хэрэгжүүлэх төсөлд нэгдэн орох	Нэгдэн орсон эвсэл	Дэлхийн байгаль орчны төсөлд нэгдэн орж, хүн амыг хар тугалгын бохирдолтод өртөх эрсдэлээс хамгаалах мэдээ, мэдээллээр хангасан байна.	ЭМЯ, ДЭМБ	НЭМҮТ, ТББ	2021-2023
7.1.6	Хүнсний зориулалтын бус хуванцар савыг ахуйн хэрэглээнд өргөн ашиглаж байгаагай холбогдуулан хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлан тогтоох	Сургалт материал	Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сэрэмжлүүлэх, ухуулан сурталчлах ажлыг зохион байгуулж, олон нийтийн хүртээл болгосон байна	ЭМЯ, ХХААХҮЯ	НЭМҮТ, ТББ	2021-2024
Үйл ажиллагааны чиглэл 2. Ахуйн шавж, мэрэгч устгал, халдваргүйтэлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх						
7.2.1	Ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтэлийн бодисыг бүртгэх журам, стандартыг шинэчлэн боловсруулах	Батлагдсан журам	Эрх зүйн орчин шинэчлэгдэнэ.	ЭМЯ, ХӨСҮТ	Ажлын хэсэг	2021-2022
Үйл ажиллагааны чиглэл 3. Ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтэлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх						
7.3.1	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрын нөхцөл, хүний нөөцөд дэмжлэгт хяналт хийх	Дэмжлэгт хяналт хийх	Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрын нөхцөл сайжирч, хүний нөөцийн чадавхи бэхжинэ.	МХЕГ, ХӨСҮТ	Аж ахуйн нэгж, байгууллага	2022-2023
7.3.2	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтэл хийх "ариутгагч" нарыг бага эмч, сувилагч нараас бэлтгэх тогтолцооны тогтвортой байдлыг хангах	Сургалтанд оролцогчдын тоо	Хүний нөөцийн чадавхи бүрдэнэ.	ЭМХТ, ХӨСҮТ, ТББ	ЭМБ	2021-2024
Үйл ажиллагааны чиглэл 4. Ахуйн шавж, мэрэгч устгал болон ариутгал, халдваргүйтэлийн бодисын бүртгэл, хэрэглээ, дасан зохицолд тандал, судалгаа хийх						
7.4.1	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтэлийн бодисын бүртгэл, ашиглалт	Ашиглаж болох бодисын тоо	Ашиглаж болох бодисын тоо, хэмжээг баталгаажуулсан байна.	БОАЖЯ, ХХААХҮЯ, ЭМЯ	ХӨСҮТ	2021-2024
7.4.2	Ахуйн шавж, мэрэгч устгал, ариутгал, халдваргүйтэлийн бодисын хэрэглээ, дасан зохицлыг судлах, үр дүнг олон нийтэд мэдээлэх	Судалгааны тайлан	Судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгосон байна.	МХЕГ, ХӨСҮТ	ЭМЯ, ХАБЭМТ	2021, 2024

Товчилсон үгийн тайлбар (Цагаан толгойн үсгийн дарааллаар)

Яамд

БОАЖЯ - Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ - Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ - Боловсрол, шинжлэх ухааны яам
СЯ - Сангийн яам
ХНХЯ - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЭМЯ - Эрүүл мэндийн яам

Засгийн газрын агентлаг, бусад байгууллага

АШУҮИС-ийн НЭМС - Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль
СХЗГ - Стандарт хэмжил зүйн газар
ЗЦА - Замын цагдаагийн алба
ЗӨСҮТ - Зоонозын өвчин судлалын үндэсний төв
МАУА - Монголын анагаах ухааны академи
МХЕГ - Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУЗН - Монголын улаан загалмай нийгэмлэг
МЭАТСНХ - Монголын эрүүл ахуй, тархвар судлаачдын нэгдсэн холбоо
НЗАА - Нийслэлийн захирагчийн ажлын алба
НМХГ - Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
НЭМГ - Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМҮТ - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ОББҮХ - Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
ОУТББ - Олон улсын төрийн бус байгууллага
ТББ - Төрийн бус байгууллага
ТоС холбоо - Тогтвортой санхүү холбоо
УГ - Усны газар
УСУГ - Ус сувгийн удирдах газар
ҮСХ - Үндэсний статистикийн хороо
ХАБЭМТ - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
ХСУХАТАҮЗЗ - Хот, суурингийн ус хангамж, ариутга татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
ХӨСҮТ - Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЦУОШГ - Цаг уур, орчны шинжилгээний газар
ШУА - Шинжлэх ухааны академи
ШУТИС - Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМБ - Эрүүл мэндийн байгууллага
ЭМБХХМ - Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент
ЭХЭМҮТ - Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМСХХ - Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр
ЭМХТ - Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЦУНБХТ - Цэвэр усны нөөц, байгаль хамгаалах төв
ӨЭМТ - Өрхийн эрүүл мэндийн төв

Орон нутгийн засаг захиргааны байгууллага

АНЗДТГ - Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
АНЭМГ - Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
АЗДТГ - Аймгийн засаг даргын тамгын газар
ЗДТГ - Засаг даргын тамгын газар

Олон улсын байгууллага

ДЭМБ - Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
НҮБХС - Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
ШХА - Швейцарийн хөгжлийн агентлаг

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 05 дугаар сарын 31
өдрийн 05 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2020 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашигласан:

Арга хэмжээний зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрэх түвшин, он		Хариуцах байгууллага
			2022	2024	
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт					
Зорилго: Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах замаар хүнийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах нөхцөлийг сайжруулна.	Амьсгалын замын цочмог халдварт өвчлөлийн түвшин	10 000 хүн амд	906.4	806.4	706.4
	Уушгины хатгалгаа өвчний өвчлөлийн түвшин	10 000 хүн амд	194.9	190.9	185.5
	5 хүртэлх насны хүүхдийн уушгины хатгалгаа өвчний өвчлөлийн түвшин	10 000 хүн амд	972.6	760.5	755.0
	Гэдэсний халдварт өвчин	10 000 хүн амд	16.3	11.8	7.3
	Зурх шигдээс өвчний шалтгаалсан нас баралт	10 000 хүн амд	2.1	2.0	1.9
Уушгины архаг бөглөрөлт өвчнөөс шалтгаалсан нас баралт	10 000 хүн амд	0.5	0.4	0.3	
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт					
Зорилт 1. Агаарын чанарыг сайжруулж, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах	Нэг хүртэлх насны хүүхдийг пневмококкийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан хувь	Хувь	94	96	96
	Эрсдэлт бүлгийн хүн амыг томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан хувь	Хувь	15	31	47
Зорилт 1. Агаарын чанарыг сайжруулж, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хүн амд хийгдсэн мэдээлэл сургалт, сурталчилгааны компанит ажил, аяны тоо	Тоо	12	16	20
	Монгол гэрийн дулаалга, халаалт, агаар сэлгэлтийн багц (СНІР)-ыг нэвтрүүлсэн аймаг, сум, дүүрэг, цэцэрлэг, өрхийн тоо	Тоо	3	0	5
	Аймаг		0	3	5
	Сум		1	2	3
	Дүүрэг		2	5	10
Цэцэрлэг		468	1100	2000	
Өрх					

	Ундны усан дахь гэдэсний савханцрын тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	9.0	8	6	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
Зорилт 2.	Ундны усан дахь нянгийн ерөнхий тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	10.0	8	6	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
	Хөрсөнд дэх гэдэсний савханцарын тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	48	46	44	
	Хөрсөн дэх Перфрингенсийн тоо нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээжийн хувь	Хувь	50	48	46	
Зорилт 3.	Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийсэн ус хангагч байгууллагын тоо	Тоо	11	15	19	Эрүүл мэндийн яам
	Жижиг суурин газарт ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулсан байгууллагын тоо	Тоо	62	66	70	
	Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай сумын эрүүл мэндийн төвийн тоо	Тоо	13	28		
Зорилт 4.	Тандалт судалгааны чиглэлээр сургалтад хамрагдсан хүний тоо	Тоо	71	113	155	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
	Уур амьсгалын эрсдэлийг бууруулах, нөлөөллийг багасгах хариу арга хэмжээний талаар сургалтад хамрагдсан хүний тоо	Тоо	5840	11914	14714	
Зорилт 5.	Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх судалгааны арга зүй эзэмшүүлэх сургалтад хамрагдсан эрүүл мэндийн салбарын судлаач, эрдэм шинжилгээ болон эрүүл мэндийн байгууллагын ажилтны тоо	Тоо	35	115		Эрүүл мэндийн яам
	Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар хийсэн судалгаа, үнэлгээний тоо	Тоо	1	2	3	
Зорилт 6.	Төвлөрсөн ариутгалын тасгийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн аймгийн нэгдсэн эмнэлгийн тоо	Тоо	13	20	21	Эрүүл мэндийн яам
	ЭМБХХМ-ийг сайжруулах чиглэлээр сургалтад хамрагдсан ажилчдын тоо	Тоо	722	1222	1500	
Зорилт 7.	Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтны ажлын байрнаас шалтгаалсан халдвар, гэмтэл авах нөхцөл, ажлын байрны эрсдлийн байдалд үнэлгээ хийх	Тоо	0	90	180	Эрүүл мэндийн яам

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах	Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн ажилчдыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэгт хамруулсан байгууллага, ажилчдын тоо	Аж ахуйн нэгж, байгууллага		Тоо	91	191	291	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
		Ажилчид						
Зорилт 7.	Ашиглаж болох ахуйн шавж, мэргэж, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын тоо			Тоо	140	400	660	Эрүүл мэндийн яам
Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тандан судлах	Хяналтад хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо			Тоо	0	92	145	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
	Шинээр бэлтгэсэн ариутгагчийн тоо			Тоо	160	640	1040	Эрүүл мэндийн хөгжлийн төв

-----000-----